

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагч төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах боломжийг хангах зорилгоор төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд энэхүү зарыг мэдээлж байна.

Төрийн жинхэнэ албан хаагчдаас тухайн орон тоо нөхөгдөөгүй тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2 дахь заалт, 33.3 дахь хэсэгт заасны дагуу тусгай шалгалт зохион байгуулна.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасны дагуу **төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг** хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- ❖ төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- ❖ зарлагдсан албан тушаалтай адил төрлийн албан тушаалын адил ангилалд ажилладаг байх;
- ❖ зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- ❖ Төрийн албан хаагчийн анкет;
- ❖ Иргэний үнэмлэхийн хуулбар;
- ❖ Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- ❖ Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- ❖ Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- ❖ Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- ❖ Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- ❖ Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- ❖ Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia-аас татан авах/.

Материал хүлээн авах:

- ❖ Хугацаа: 5 хоног, 2025 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 17.00 цаг хүртэл
- ❖ Хүлээн авах хаяг: Ажлын байрны жагсаалтад оруулсан тухайн байгууллагын цахим шуудан
- ❖ Холбоо барих утас: Ажлын байрны жагсаалтад оруулсан тухайн байгууллагын утас